Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 дугаар тушаалын
10 дугаар хавсралт

# НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ ЖАЛБУУСҮРЭНГИЙН НАРМАНДАХЫН 2025 ОНЫ 4 ДҮГЭЭР УЛИРЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

| ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН МЭДЭЭЛЭЛ | |
|---|---|
| Эцэг / эхийн нэр: | Жалбуусүрэн |
| Өөрийн нэр: | Нармандах |
| Байгууллагын нэр: | Чингэлтэй дүүргийн нийгмийн даатгалын газар |
| Нэгжийн нэр: | Захиргаа, хяналтын хэлтэс |
| Албан тушаалын нэр: | Нийгмийн хамгааллын улсын байцаагч |

## НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Гүйцэтгэлийн түвшин | | | | Төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал | | | | Нийлбэр оноо |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | | | | 4 | | | | 3+4 |
| | | 60 оноо | | | | 10 оноо | | | | 70 оноо |
| | | | 40% | [illegible] | [illegible] | 0% | 40% | 70 | 100% | |
| ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ | | | | | | | | | | |
| | Арга хэмжээ №1. | | | | + | | | | + | 70 |
| | Арга хэмжээ №2. | | | | + | | | | + | 70 |
| | Арга хэмжээ №3. | | | | + | | | | + | 70 |
| | Арга хэмжээ №4. | | | | + | | | | + | 70 |
| | Арга хэмжээ №5. | | | + | | | | + | | 49 |
| | Арга хэмжээ №6. | | | | + | | | | + | 70 |
| | Арга хэмжээ №7. | | | + | | | | + | | 49 |
| | Арга хэмжээ №8. | | | | + | | | | + | 70 |
| | Арга хэмжээ №9. | | | | + | | | | + | 70 |
| НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ | | | | | | | | | | |
| | 1-р улирлын нэмэлт ажил | | | | | | | | | |
| | 2-р улирлын нэмэлт ажил | | | | | | | | | |
| | 3-р улирлын нэмэлт ажил | | | | | | | | | |
| | 4-р улирлын нэмэлт ажил | | | | + | | | | + | 70 |
| **Дундаж оноо** | | | | | | | | | | **65,8** |

## ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвараа сайжруулах арга хэмжээ | Гүйцэтгэлийн түвшин | | | | Нийт (15 оноо) |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | | | | 4 |
| | | [illegible] | [illegible] | 70% | 100% | |
| | Арга хэмжээ №1. | | | | + | 15 |
| | Арга хэмжээ №2. | | | | + | 15 |
| | Арга хэмжээ №3. | | | | + | 15 |
| **Дундаж оноо** | | | | | | **15** |

## ГУРАВ. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ

| № | Хандлага, ёс зүй, ур чадвар | Нэгжийн даргын үнэлгээ | | | Нийт (10 оноо) |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | | | 4 |
| 1. | Хандлага, ёс зүй | 1 | 3 | 5 | 10 |
| 2. | Төлөвлөх, зохион байгуулах | 1 | 3 | 5 | 10 |
| 3. | Шийдвэр гаргах болон асуудлаа тодорхойлох | 1 | 3 | 5 | 10 |
| 4. | Дүн шинжилгээ хийх | 1 | 3 | 5 | 10 |
| 5. | Шинийг санаачлах | 1 | 3 | 5 | 10 |
| 6. | Хариуцлага хүлээх | 1 | 3 | 5 | 10 |
| 7. | Ажлын цаг ашиглалт, цагийн менежмент | 1 | 3 | 5 | 10 |
| Ажлын онцлогоос хамаарсан ур чадвар | | | | | |
| 1. | Мэргэжлийн ур чадвар №1. | 1 | 3 | 5 | 10 |
| 2. | Мэргэжлийн ур чадвар №2. | 1 | 3 | 5 | 10 |
| 3. | Мэргэжлийн ур чадвар №3. | 1 | 3 | 5 | 10 |
| **Дундаж оноо** | | | | | **10** |

## ДӨРӨВ. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ

| № | Хандлага, ёс зүй, ур чадвар | Хамт олны үнэлгээ | | | Нийт (5 оноо) |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | | | 4 |
| 1. | Манлайлал | 1 | 3 | 5 | 5 |
| 2. | Баг, хамтын ажиллагаа | 1 | 3 | 5 | 5 |
| 3. | Харилцаа | 1 | 3 | 5 | 5 |
| **Дундаж оноо** | | | | | **5** |

## ТАВ. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ

| № | Хандлага, ёс зүй, ур чадвар | Хэрэглэгчийн үнэлгээ | | | Нийт (5 оноо) |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | | | 4 |
| 1. | Ажилтан танд туслахад бэлэн байсан уу? | 1 | 3 | 5 | 5 |
| 2. | Ажилтны эелдэг таатай харилцаа | 1 | 3 | 5 | 5 |
| 3. | Ажилтны бүх үйлчлүүлэгчидтэй ижил тэгш харилцах байдал | 1 | 3 | 5 | 5 |
| 4. | Ажилдаа хариуцлагатай ханддаг байдал | 1 | 3 | 5 | 5 |
| 5. | Ажилтны цаг баримтлах, ашиглах байдал | 1 | 3 | 5 | 5 |
| 6. | Ажилтны асуудлыг нэг удаагийн хандалтаар шийдэж өгөхийг хичээдэг байдал | 1 | 3 | 5 | 5 |
| 7. | Ажилтны мэргэжлийн ур чадвар, мэдлэг | 1 | 3 | 5 | 5 |
| 8. | Ажилтны шударга байдал / Гар харах / | 1 | 3 | 5 | 5 |
| **Дундаж оноо** | | | | | **5** |

## ЗУРГАА. ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

| | | |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (*70 хүртэлх оноо*) | **65,8** |
| 2. | Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт (*15 хүртэлх оноо*) | **15** |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (*15 хүртэлх оноо*)<br>а. ( Нэгжийн даргын үнэлгээ )<br>б. ( Хамт олны үнэлгээ )<br>в. ( Хэрэглэгчийн үнэлгээ ) | **15** |
| **Нийт үнэлгээ** | | **95.8** |

| | |
|---|---|
| Ерөнхий үнэлгээ. | [illegible] |

[illegible]

Үнэлгээний мөрөөр авах арга хэмжээ / урамшуулах, хариуцлага тооцох г.м /-ний санал:

.......................................................................................................................................................

.......................................................................................................................................................

Нэгжийн даргын тэмдэглэл / ажлын гүйцэтгэлийг хэрхэн сайжруулах талаар зөвлөмж г.м /:

.......................................................................................................................................................

.......................................................................................................................................................

***Үнэлгээ өгсөн:*** ***Нэгжийн дарга***

Хэлтсийн дарга .................................... /Т.Гэрэлтунгалаг/

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

2025.12.22 *(огноо)*

***Үнэлгээг баталгаажуулсан:*** ***Үнэлгээний багийн гишүүн***

Хэлтсийн дарга .................................... Т.ГЭРЭЛТУНГАЛАГ ............/

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

2025.12.22 ..................... *(огноо)*

.................................... ....................................

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

2025.12.22 ..................... *(огноо)*

***Үнэлгээтэй танилцсан:*** ***Төрийн жинхэнэ албан хаагч:***

Нийгмийн хамгааллын улсын байцаагч .................................... / Ж.Нармандах /

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

2025.12.22 *(огноо)*

***Үнэлгээг баталгаажуулсан:*** ***Төсвийн шууд захирагч***

Газрын дарга .................................... /А.Даваадорж/

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

.............................. *(огноо)*

9025051015 ☎ 9080821

# НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ ЖАЛБУУСҮРЭН ОВОГТОЙ НАРМАНДАХЫН 2025 ОНЫ ДӨРӨВДҮГЭЭР УЛИРАЛД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 09-ний өдөр Улаанбаатар хот

Чингэлтэй дүүргийн нийгмийн даатгалын газрын Нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагч Ж.Нармандах миний бие тайлант хугацаанд дараах ажлыг гүйцэтгэсэн болно. Үүнд:

Нийгмийн даатгалын ерөнхий газраас 2025 оныг "Даатгуулагчийг дэмжих, Нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах" жил болгон зарласан. Энэхүү зорилтын хүрээнд Нийгмийн даатгалын ач холбогдлыг ажил олгогч, даатгуулагч, иргэдэд сурталчлан таниулан, ойлгуулах, харилцан уялдаа холбоо сайжруулах, нийгмийн даатгалын даатгалын үйлчилгээг илүү хүртээмжтэй үр ашигтай болгох, ажил олгогч даатгуулагчдын нийгмийн даатгалын шимтгэлийн өр авлагыг барагдуулах хамралтыг нэмэгдүүлэх зэрэг ажил төлөвлөн ажиллаж байна.

## Нийгмийн хамгааллын хяналтын чиглэлээр объектын эрдэлийн үнэлгээ хийж, хяналт шалгалтын мэдээллийг мэдээллийн нэгдсэн санд бүртгэх, хяналт шалгалтын бодлого, төлөвлөлтийг хэрэгжүүлэх талаар:

Засгийн газрын 2023 оны 195 дугаар тогтоолын 7 дугаар хавсралтаар баталсан "Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хяналт шалгалтын объектыг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур үзүүлэлт"-ийн дагуу заагдсан ангилалуудад үнэлгээ хийж, өндөр эрсдэлтэй гэж үзсэн 127 объектыг үнэлж, үүнээс хамгийн өндөр эрсдэлтэй гэж үзсэн 20 объектыг сонгон "2026 оны хяналт шалгалтын төлөвлөгөө"-нд оруулах саналыг 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 01/494 тоот албан бичгээр НДЕГ-ын Хяналт шалгалтын газарт хүргүүлсэн.

2026 онд заагдсан чиглэлийн дагуу Чингэлтэй дүүргийн Хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн хамгааллын 3 чиглэлээр хамтран хяналт шалгалт хийх улсын байцаагч нарын төлөвлөгөөт хяналт шалгалтын объектын жагсаалт, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын чиглэлийн саналын төсөл боловсруулан НДЕГ-ын Хяналт шалгалтын газарт 10 дугаар сарын 30-ны өдөр хүргүүлсэн.

## Дотоод хяналт шалгалтын талаар:

Тэтгэврийн хувийн хэргийг массивтай тулган тооллого хийж дуусгасан. Үүнд:

- 1 дүгээр хорооны өндөр насны, хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэврийн 909 хувийн хэрэг;
- 2 дугаар хорооны өндөр насны, хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэврийн 691 хувийн хэрэг;
- 3 дугаар хорооны өндөр насны, хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэврийн 1171 хувийн хэрэг;

- 4 дүгээр хорооны өндөр насны, хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэврийн 1148 хувийн хэрэг;
- 5 дугаар хорооны өндөр насны, хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэврийн 1112 хувийн хэрэг;
- 6 дугаар хорооны өндөр насны, хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэврийн 1488 хувийн хэрэг;
- 7 дугаар хорооны өндөр насны, хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэврийн 1738 хувийн хэрэг;
- 8 дугаар хорооны өндөр насны, хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэврийн 815 хувийн хэрэг.

Нийт 9072 тэтгэврийн хувийн хэргийг массивтай тулган тооллого хийж, цэгцлэж дуусгасан.

Тооллогоор тэтгэврийн хувийн хэрэг массивын жагсаалтын дагуу хайрцаглагдаагүй, төрөл өөр хайрцагт хийгдсэн, хувийн хэргийн хайрцаг чихэлдсэн, урагдсан, нас барсан тэтгэвэр авагчийн хувийн хэрэг архивлагдаагүй зэрэг зөрчил илэрснийг тооллого хийж байх явцад засаж залруулсан.

Дээд шатны байгууллага болон Газрын даргын гаргасан тушаал шийдвэрийн талаар:

Газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 04 тоот удирдамжийн дагуу Монголын төмөр зам ТӨХК-д Нийгмийн даатгалын багц хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон бусад холбогдох хуулиуд, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гаргасан тогтоол, шийдвэр, журам, зааврын биелэлтийг шалгах, шимтгэлийн өр, авлагын тооцоо түүний барагдуулалтын байдлыг шалгах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах зорилгоор хяналт шалгалт хийсэн.

Байгууллагын шинэ жилийн бүх арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсэгт томилогдон ажилласан.

“Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх”

- 10 дугаар сарын 08-ны өдөр Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран “Авлига, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа” сургалт;
- 10 дугаар сарын 15-ны өдөр тус газрын Ёс зүйн дэд хорооноос зохион байгуулсан “Төрийн болон албаны нууцын тухай” хуулийн сургалт;
- 10 дугаар сарын 19-ны өдөр “Ахмадаас суралцъя, чөлөөт ярилцлага хийх” сургалтыг зохион байгуулсан;
- 10 дугаар сарын 27-ны өдөр “Байгууллагын соёл ба үйлчилгээний чанар” сургалт;

- 10 дугаар сарын 29-ны өдөр Халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай сургалтыг Хөдөлмөр, халамжийн хэлтэстэй хамтран зохион байгуулсан;
- 10 дугаар сарын 30-ны өдөр “Монгол бичгийг дижитал орчинд эзэмших нь” сэдвээр Болорсофт, Чимэгэ, Эгүнэ системийг үүсгэн байгуулагч, гүйцэтгэх захирал С.Бадралын сургалт;
- 10 дугаар сарын 31-ны өдөр Санхүүгийн мэдээллийн технологийн төв, УТҮГ-ийн Санхүүгийн инновац хөгжүүлэлтийн газрын Системийн аналист Э.Энэрэл “Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн систем”-ийн сургалт;
- 10 дугаар сарын 31-ний өдөр НДЕГ, ШШГГ-тай хамтран зохион байгуулсан Хууль зүйн мэдлэг дээшлүүлэх ээлжит сургалт;
- 11 дүгээр сарын 06-ны өдөр НДЕГ-ын Ёс зүйн дэд хорооноос салбарын нийт Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүдийг оролцуулсан цахим уулзалт;
- 11 дүгээр сарын 07-ны өдрийн мэдээллийн цагаар Засгийн газрын 43 дугаар тогтоолоор баталсан "Хяналт шинжилгээ хийх журам", "Үнэлгээ хийх журам", "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх журам", “Бодлогын баримт бичиг болон байгууллагын үйл ажиллагааг төлөвлөх, тайлагнахад анхаарах асуудал” сэдвээр Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын Үнэлгээ, мониторингийн газрын ахлах референт Д.Отгон, Үнэлгээ, мониторингийн хэлтсийн ахлах шинжээч Ш.Бумаажав нарын цахим сургалт,
- НДЕГ-ын даргын А/267 дугаар тушаалаар баталсан “Заавар батлах тухай”, “Тэтгэмж бодох заавар”-ыг баталсантай холбогдуулан 11 дүгээр сарын 12-ны өдөр анхаарах асуудлуудын талаарх сургалт,
- НДЕГ-н Ёс зүйн дэд хорооноос 11 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулсан ёс зүйн гишүүдийг чадавхжуулах сургалт;
- НДЕГ-аас зохион байгуулсан Нийгмийн даатгалын улсын байцаагчийн шалгалтад бэлтгэх, Нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчдын мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх, хуулийн зорилт, хэрэгжилтийг хангах, байцаагч ажилтнуудыг чадавхжуулах сургалтад 11 дүгээр сарын 12-ноос 27-ны өдрүүдэд цахимаар хамрагдсан.

ТАНИЛЦСАН:

ЗАХИРГАА, ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА — Т.ГЭРЭЛТУНГАЛАГ

ТАЙЛАН БИЧСЭН:

НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ — Ж.НАРМАНДАХ